



АРХАНГАЙ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудитын код: АРА-2017/13/СТА-ТШЗ

1. Аудитын гэрчилгээ
2. Аудитын тайлан
3. Менежмент захидал
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: arkhangai.prokuror@yahoo.com

Тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр

Утас: 70333141

Аудитын менежер: Т.Байгалмаа

Утас: 70332860

Ахлах аудитор: Н.Алтантуяа

Утас: 70333019

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	7
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.12	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
3.1	Зардал:.....	11
3.2	өр төлбөр:.....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
**АРХАНГАЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: (976) 7033-3141
E-mail: arkhangai@audit.gov.mn

2017.04.06 № 05

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

АРХАНГАЙ АЙМГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Б.МЭЭПАМ ТАНАА

Аймгийн Прокурорын газрын төсвийн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккрузал сууриар бэлтгэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Архангай аймгийн Аудитын газар аудит хийлээ.

Прокурорын газрын төсөв захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС) түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл:

Төрийн Аудитын байгууллага нь аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Прокурорын газрын төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуусан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Прокурорын газрын төсвийн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар журмуудын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБАЯР

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Прокурорын газрын төсвийн захирагч Б.Мээпамд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэн оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэхь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Архангай аймгийн Прокурорын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Архангай аймгийн Прокурорын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.01.18-наас 2017.02.01-ний хооронд хийж, аудитын тайланг 2017.02.04-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, хариуцаж хэрэгжүүлэв.

Архангай аймгийн Прокурорын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа төрийн аудитын байгууллагад 2017.01.18-ны өдрийн 02/142 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Архангай аймгийн Прокурорын газар хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд: Аймгийн прокурорын газрын үйл ажиллганы чиглэлийг Прокурорын байгууллагын тухай хуулийн 2 дугаар зүйлд **“Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн”** гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд Архангай аймгийн Прокурорын газар нь 2016 онд **“Хяналтын ажлын чанарын үзүүлэлтийг мэдэгдэхүйц сайжруулах, Прокурор ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх”** зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Архангай аймгийн Прокурорын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Архангай аймгийн Прокуроры газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан өөрчлөлт байхгүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аймгийн Прокурорын газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Улсын Ерөнхий Прокурорын газрын дотоод аудитын албанаас дотоод хяналт шалгалтуудыг хийж заавар зөвлөгөө өгч ажилладаг ба тайлант хугацаант хяналт шалгалт хийгдсэн гэх боловч шалгалтын дүнгийн талаарх мэдээлэл байхгүй байна.

Архангай аймгийн Прокурорын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Архангай аймгийн Прокурорын газрын санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “aculous” програм хангамжийг ашиглажээ.

Санхүүгийн тооцоолох группын “Acolous 3.0” программыг хэрэглэж байна. Уг программ нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандарт болон Монгол улсын НББ-ийн стандартад нийцсэн тул Сангийн яамнаас ашиглах зөвшөөрөл авсан байна. Тус хувилбар нь төсөвт байгууллагын нягтлан бодогчид өдөр тутмын үйл ажиллагааны анхан шатны мэдээллийг бүртгэх, санхүүгийн мэдээ, тайлан гаргахад зориулагдсан байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Архангай аймгийн Прокурорын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 20 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.5 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл өндөр гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-В-4.3 маягад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин дунд байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 5 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт зардал-ийг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тухайн байгууллага алдагдал тайлагнасан учир материаллаг байдлын суурийг нийт орлогоос тооцоход учир дутагдалтай, нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн бага байгаа тул байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Архангай аймгийн Прокурорын газрын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 330.9 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 3.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтийг гүйцэтгэлийн шатанд 1 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр тооцох нь зүйтэй гэж үзлээ.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 6 чиглэлээр 20 эрсдэлтэй асуудалд 20 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 13 хувь буюу 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	4,344,160.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	2	4,344,160.00	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2016 оны санхүүгийн тайлангийн аудиттай уялдуулан 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийхэд 0.5 сая төгрөгийн урсгал засварын материалыг шууд зардал болгосон, 0.4 сая төгрөгийн бараа материалыг бөөн дүнгээр орлого авч зарцуулсан, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 8.1 сая төгрөгийн өр төлбөртэй байсан зөрчилд зөвлөмж, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр, даргын тушаал шийдвэргүй 4.3 сая төгрөгийн бараа материалыг акталсан зөрчилд албан шаардлага хүргүүлэн зөрчлийг бүрэн арилгуулан ажилласан байна.

Харин санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах асуудлыг менежмент захидлаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

1. Ээлжийн амралтын цалинг тооцож олгохдоо ЭМНХС-ын 2000 оны 166-р тушаалаар баталсан ээлжийн амралтын олговор тооцох журмыг зөрчиж зөвхөн нэг сарын цалингаас дундажлан амралтын мөнгийг тооцож олгосонд ЭМНХС-ын 2000 оны 166-р тушаалаар баталсан ээлжийн амралтын олговор тооцох журмыг мөрдөж ажиллах.
2. Тус байгууллага нь нийт 4.3 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Үүний шалтгаан нь шуудан холбооны зардлын төсөв танагдсанаас үүдэлтэй үүссэн бөгөөд өр төлбөрийг барагдуулахад тодорхой арга хэмжээ авч холбогдох дээд байгууллагад санал хүргүүлэн шийдвэрлүүлж ажиллах.

Дээрх илэрсэн асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлэг “Менежементийн захидал”-д холбогдох зөвлөмжийн хамт орууллаа.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аймгийн Прокурорын газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудиттай уялдуулан завсрын аудит хийнэ. Дараагийн аудитаар дараах асуудалд анхаарал хандуулна. Үүнд: хөрөнгийн өөрчлөлт ажиглагдвал холбогдох шийдвэр, нотлох баримтыг хугацаанд нь аудитад хамруулна. Мөн ажиллагсдын ээлжийн амралтын цалин олголт, тооцоог давтан шалгана.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Архангай аймгийн Прокурорын газрын өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 295.2 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	295,170,700.00	295,170,700.00	100.0%	0.0
1.1	Урсгал зардал	295,170,700.00	295,170,700.00	100.0%	0.0
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0	0.0
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр	295,170,700.00	295,170,700.00	100.0%	0.0
2.1	Улсын төсвөөс санхүүжих	295,170,700.00	295,170,700.00	100.0%	0.0

Төсөвт зардлыг 100 хувь бүрэн зарцуулсан байна. Харин байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардлыг бүлэг дотор 0.1- 0.9 сая төгрөгөөр гүйлгэн зарцуулжээ.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 3.6 сая төгрөгийг авч урсгал зардалд зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Архангай аймгийн Прокурорын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллагын 2016 оны шилэн дансны мэдээллийг шалгахад хуульд мэдээлэхээр заасан мэдээллүүдийг бүрэн оруулсан байна.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Зөвлөмжийн биелэлтийг Архангай аймгийн Прокурорын газрын 2016 оны 06.08-ны өдрийн 2/408 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Архангай аймгийн Прокурорын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Архангай аймгийн Прокурорын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Архангай аймгийн Прокурорын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан асуудлууд нь цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Зардал:

Илрүүлэлт

Ээлжийн амралтын цалинг тооцож олгохдоо ЭМНХС-ын 2000 оны 166-р тушаалаар баталсан ээлжийн амралтын олговор тооцох журмыг зөрчиж зөвхөн нэг сарын цалингаас дундажлан амралтын мөнгийг тооцож олгосон байна.

Зөвлөмж

✓ Иймд цаашид ажилчдын ээлжийн амралтын олговрыг тооцож олгохдоо ЭМНХС-ын 2000 оны 166-р тушаалаар баталсан "Ээлжийн амралтын олговор тооцох журам"-ын 3-д "Ээлжийн амралтын олговрыг уг ажилтны ээлжийн амралт эдлэхээс өмнөх ажлын нэг жилийн хугацааны дундаж цалин хөлсийг үндэслэн тодорхойлно" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

Эрсдэл

- Цалингийн зардал буруу тооцогдох

Төсвийн захирагчийн хариу

3.2 ӨР ТӨЛБӨР:

Илрүүлэлт

- ✓ Нийт 4,344.1 мянган төгрөгийн өр төлбөртэй байна. Үүний шалтгаан нь шуудан холбооны зардлын төсөв танагдсанаас үүдэлтэй үүсжээ.

Зөвлөмж

1. Өр төлбөрийг барагдуулахад тодорхой арга хэмжээ авч холбогдох дээд байгууллагад санал хүргүүлэн шийдвэрлүүлэх.
2. Цаашид Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Эрсдэл

- Төсвийн тухай хууль зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийн биелэлтийг 2017.06.25-ны дотор манайд албан бичгээр ирүүлнэ үү.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,463,022.00	162,217.00
33	АВЛАГА	131,291.00	17,767.00
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	131,291.00	17,767.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,331,731.00	144,450.00
354	Хангамжийн материал	5,331,731.00	144,450.00
35410	Бичиг хэргийн материал	277,500.00	59,250.00
35420	Аж ахуйн материал	5,054,231.00	85,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	146,373,082.20	125,945,420.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	146,373,082.20	125,945,420.86
392	Биет хөрөнгө	146,313,498.72	125,945,420.86
39201	Барилга, байгууламж	94,822,500.00	94,822,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,964,368.39	-7,544,743.43
39203	Авто тээврийн хэрэгсэл	72,400,000.00	67,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-51,645,233.88	-58,461,900.60
39205	Машин, тоног төхөөрөмж	28,160,064.00	29,506,824.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-15,310,886.42	-21,118,359.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,848,000.00	21,414,440.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,554,656.75	-10,686,659.89
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,447,600.00	14,447,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,889,519.84	-4,334,279.76
393	Биет бус хөрөнгө	59,583.48	00.00
39301	Програм хангамж	715,000.00	715,000.00
39302	Хасагдуулга	-655,416.52	-715,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	151,836,104.20	126,107,637.86
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	00.00	4,344,160.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	4,344,160.00
413	Өглөг	00.00	4,344,160.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	4,344,160.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	151,836,104.20	121,763,477.86
51	Засгийн газрын хувь оролцоо	151,836,104.20	121,763,477.86
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	168,926,546.00	168,926,546.00
51101	Өмч: -Төрийн өмч	168,926,546.00	168,926,546.00
512	Хуримтлагдсан үр дүн	-24,451,441.80	-54,524,068.14
51210	Өмнөх үеийн үр дүн	-24,451,441.80	-24,451,441.80
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-30,072,626.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,361,000.00	7,361,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	151,836,104.20	126,107,637.86

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	287,284,019.00	300,793,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,639,319.00	2,023,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,639,319.00	2,023,200.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,639,319.00	2,023,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,639,319.00	2,023,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	282,644,700.00	298,770,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	281,144,700.00	295,170,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	281,144,700.00	295,170,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,500,000.00	3,600,000.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	1,500,000.00	3,600,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	305,998,424.55	330,866,526.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	303,175,018.55	301,327,326.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	303,175,018.55	301,327,326.34
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	189,109,413.00	194,074,241.00
210101	Цалин	175,425,412.00	182,506,240.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,684,001.00	8,388,001.00
210105	Гэрээтийн цалин	6,000,000.00	3,180,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,008,168.00	21,280,483.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	17,259,207.00	13,970,288.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	772,749.00	1,546,557.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	949,836.00	1,948,517.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	189,966.00	386,639.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,836,410.00	3,428,482.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,480,132.00	26,941,765.00
210301	Гэрэл цахилгааны зардал	3,659,888.00	4,742,320.00
210302	Түлш, халаалтын зардал	20,923,434.00	19,240,125.00
210303	Цэвэр, бохир усны зардал	2,896,810.00	2,959,320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,022,674.00	32,476,976.00
210401	Бичиг хэргийн материал	7,152,403.00	5,933,786.00
210402	Тээвэр, шатахууны зардал	4,212,607.00	6,946,282.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	11,504,108.00	13,688,477.00
210404	Ном, хэвлэлийн зардал	74,600.00	00.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	4,078,956.00	5,908,431.00
2105	Нормативт зардал	119,300.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	119,300.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,131,108.00	500,000.00
210604	Урсгал засвар	11,131,108.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,423,600.00	1,410,100.00
210702	Дотоод томилолтын зардал	3,423,600.00	1,410,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	485,000.00	302,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	76,500.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	150,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	97,400.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	00.00	88,000.00
210807	Газрын төлбөр	155,000.00	41,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,395,623.55	24,340,861.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	239,300.00	2,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,156,323.55	22,340,861.34

Прокурорын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,823,406.00	29,539,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,543,100.00	29,539,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	28,939,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,543,100.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,280,306.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,280,306.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	-18,714,405.55	-30,072,626.34
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	2,466,220.28	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,466,220.28	00.00
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-2,466,220.28	00.00
7	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	-21,180,625.83	-30,072,626.34

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	284,791,649.00	299,532,505.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	284,791,649.00	299,532,505.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	281,144,700.00	295,170,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	281,144,700.00	295,170,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,500,000.00	3,600,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	1,500,000.00	3,600,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,146,949.00	761,805.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,146,949.00	761,805.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	284,592,649.00	299,532,505.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	284,592,649.00	299,532,505.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	279,622,294.00	269,231,500.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	187,975,626.00	193,932,900.00
210101	Үндсэн цалин	173,570,176.00	177,939,830.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,005,450.00	7,030,070.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,400,000.00	8,963,000.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	22,179,000.00	21,308,300.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	18,315,480.00	14,391,100.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	776,430.00	1,225,600.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	951,890.00	1,676,900.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	194,110.00	449,300.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,941,090.00	3,565,400.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	27,480,132.00	29,492,800.00
210301	Гэрэл цахилгааны зардал	3,659,888.00	4,742,320.00
210302	Түлш, халаалтын зардал	20,923,434.00	21,791,160.00
210303	Цэвэр, бохир усны зардал	2,896,810.00	2,959,320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,309,600.00	19,524,500.00
210401	Бичиг хэрэг	6,062,240.00	5,015,436.00
210402	Тээвэр, шатахуун	4,203,707.00	6,946,282.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,582,491.00	7,172,982.00
210404	Ном, хэвлэл	115,400.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,345,762.00	389,800.00
2105	Нормативт зардал	383,900.00	360,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	383,900.00	360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,706,136.00	500,000.00
210604	Урсгал засвар	9,706,136.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,830,100.00	1,410,100.00
210701	Дотоод албан томилолт	2,830,100.00	1,410,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	485,000.00	302,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	00.00	76,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	00.00

Прокурорын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	97,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	88,000.00
210807	Газрын төлбөр	155,000.00	41,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,272,800.00	2,400,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,272,800.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	00.00	400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,970,355.00	30,301,005.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,690,049.00	30,301,005.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	2,146,949.00	761,805.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	28,939,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,543,100.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,280,306.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,280,306.00	00.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	199,000.00	00.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	199,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	199,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	199,000.00	00.00
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /ТӨҮГ/	199,000.00	00.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-199,000.00	00.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	00.00	00.00	00.00	00.00
C05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	00.00	00.00	00.00	00.00
C08	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	168,926,546.00	7,361,000.00	-24,451,441.80	151,836,104.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	168,926,546.00	7,361,000.00	-24,451,441.80	151,836,104.20
D04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	00.00	00.00	00.00	00.00
D05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	00.00	00.00	-30,072,626.34	-30,072,626.34
D09	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	168,926,546.00	7,361,000.00	-54,524,068.14	121,763,477.86

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	295,170,700.00	295,170,700.00	-	100.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	295,170,700.00	295,170,700.00	-	100.0
210	Бараа, үйлчилгээний зардал	265,631,500.00	265,631,500.00	-	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,932,900.00	193,932,900.00	-	100.0
210101	Үндсэн цалин	177,863,600.00	177,939,830.00	(76,230.00)	100.0
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	7,106,300.00	7,030,070.00	76,230.00	101.1
210105	Гэрээт ажлын хөлс	8,963,000.00	8,963,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,308,300.00	21,308,300.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	14,391,100.00	14,391,100.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,225,600.00	1,225,600.00	-	100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	1,676,900.00	1,676,900.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	449,300.00	449,300.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,565,400.00	3,565,400.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,492,800.00	29,492,800.00	-	100.0
210301	Гэрэл цахилгаан	3,780,000.00	4,742,320.00	(962,320.00)	79.7
210302	Түлш, халаалт	22,760,800.00	21,791,160.00	969,640.00	104.4
210303	Цэвэр, бохир ус	2,952,000.00	2,959,320.00	(7,320.00)	99.8
2104	Хангамж, бараа материалын зардал	15,924,500.00	15,924,500.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	3,023,500.00	3,065,436.00	(41,936.00)	98.6
210402	Тээвэр (шатахуун)	5,848,500.00	5,296,282.00	552,218.00	110.4
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6,652,000.00	7,172,982.00	(520,982.00)	92.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	400,500.00	389,800.00	10,700.00	102.7
2105	Нормативт зардал	360,000.00	360,000.00	-	100.0
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	360,000.00	360,000.00	-	100.0
2106	Эд хогшил худалдан авах	500,000.00	500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,410,100.00	1,410,100.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	1,410,100.00	1,410,100.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	302,900.00	302,900.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,500.00	76,500.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,400.00	97,400.00	-	100.0
210806	Мэдээллийн технологийн зардал	88,000.00	88,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	41,000.00	41,000.00	-	100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	2,400,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	400,000.00	-	100.0
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,539,200.00	29,539,200.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,539,200.00	29,539,200.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,939,200.00	28,939,200.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	600,000.00	600,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	295,170,700.00	295,170,700.00	-	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	295,170,700.00	295,170,700.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	295,170,700.00	295,170,700.00	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	-	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18.00	18.00	-	100.0
	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00	-	100.0

